



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС 2016-2020 ОНЫ  
СОНГУУЛИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД БАРИМТЛАЖ АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛ**

**Нэг. Зорилт**

Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон, иргэдийн эрх зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, сумын нийгэм, эдийн засгийн зорилт, дэд бүтцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж байгууллага, иргэд сонгогчдын санал санаачлагад тулгуурлан, оролцох идэвхийг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэх замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулах, төрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, төсвийн орлого, зарлага, зарцуулалтын байдлыг ил тод нээлттэй байлгах, нутгийн өөрөө удирдах ёсыг орон нутгийн түвшинд боловсронгуй болгож, өөрөө удирдах байгууллагын бие дааж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллахад Үндсэн чиглэлийн зорилт оршино.

**Хоёр. Эрх зүй, төрийн байгуулалтын бодлогын талаар**

**Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа болон иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг хүртээмжтэй, иргэдэд нээлттэй ил тод байлгах, хууль эрх зүйн сургалтыг тогтмолжуулах замаар иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль дээдлэх, хэрэгжүүлэх ёс суртахууныг төлөвшүүлэхийг зорино.**

2.1 Иргэдийн хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлж эрх зүйн сургалт сурталчилгааг тогтмолжуулах, Хурал, Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төсөлд иргэдийн санал санаачлагыг бүрэн тусгах

2.2 Төлөөлөгчдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох, хурлын болон ажлын хороодын үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцуулах, сонгогдсон тойрогтоо ажиллах арга замыг боловсронгуй болгож дээд, доод шатны байгууллагуудтай зохих түвшинд харилцах, бие дааж ажиллах боломж, нөхцлийг бүрдүүлэх

2.3 ИТХ, Засаг даргын үйл ажиллагааг иргэдэд тогтмол нээлттэй ил тод байлгах, иргэдийн оролцоог идэвхижүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх

2.4 ИТХ, Засаг дарга, түүний Тамгын газар болон төсвийн нийт байгууллагын төсөв, түүний зарцуулалт, сумын төсвийн орлого, зарлагын дүнг иргэдэд мэдээлж нээлттэй байлгах, "Шилэн дансны хууль"-ийг хэрэгжүүлэх

2.5 Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай болгож, хүний төлөө шударга, ил тод ажиллах зарчмыг баримтлан, хүнд суртал, чирэгдэл гаргахгүй байхад төрийн албан хаагчдын үйл ажиллагааг чиглүүлж, төрийн үйлчилгээтэй холбоотой иргэдийн санал хүсэлт, гомдлыг цаг алдалгүй шуурхай хүлээн авч шийдвэрлэж, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, иргэдэд эргэж мэдээлэх тогтолцоог шинэчлэх

2.6 Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулах, хариуцсан ажилтан ажиллуулах, ИТХ-ын хяналтын чиг үүргийг өндөржүүлж Нийгэм, Эдийн засгийн зорилт, төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, Засаг даргын мөрийн хөтөлбөр, суманд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнд хяналт тавьж ажиллах



2.7 ИТХ, БИНХ-ын архив албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, холбогдох мэдээ, мэдээллийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомжийн дагуу хөтлөх

2.8 Иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэн, архидан согтуурах явдалтай тэмцэх тэмцлийг эрчимжүүлэх, гэмт хэрэг зөрчлийг багасгах, хүүхэд залуучуудыг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, уг ажилд оролцох олон нийтийн оролцоог идэвхижүүлэх тэдэнтэй хамтарч ажиллах

### **Гурав. Эдийн засгийн бодлогын талаар**

Эдийн засгийн бодлогыг иргэдэд ил тод байлгах, төсвийн үргүй зардлыг багасгах, жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр шинээр бий болгох талаар бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1 Төсвийн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, түүнийг эрчимжүүлэх, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж төсвийн ил тод байдлыг хангах, орлогын шинэ эх үүсвэр бий болгох арга замуудыг судалж шийдвэрлүүлэх

3.2 Иргэдийн эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх, жил бүр улс, сангуудын хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд иргэдийн санал санаачлагыг тусгах, хэрэгжилтэнд хяналт тавих боломж нөхцлийг хангах, иргэдийг идэвхижүүлэх, нээлттэй эдийн засгийн бодлого баримтлан ажиллах

3.3 Төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавьж, төсвийн үргүй зардлыг хязгаарлах, төсөв хэмнэж ажиллахад анхаарах

3.4 Гадаадын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих татан оруулах, тэдгээрийн хөрөнгө оруулалттай жижиг дунд үйлдвэрүүд байгуулах арга замыг эрэлхийлэх

3.5 Орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх үүднээс нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж батлах, эрх хэмжээнийхээ хүрээнд эзэмших, ашиглах, захиран зарцуулах тухай асуудлыг шийдвэрлүүлэх

### **Дөрөв. Нийгмийн бодлогын талаар**

**Хүүхэд залуучуудад сурч боловсрох, иргэдэд хөдөлмөр эрхлэх боломж нөхцлийг бий болгох ажлын байр нэмэгдүүлэх, төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай түргэн шуурхай болгоно.**

4.1 Ерөнхий боловсролын сургууль, ясли, цэцэрлэгийн хүүхдийн багтаамжийг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх талаар бодлого боловсруулах

4.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, багийн эмчийн үйлчилгээг өргөжүүлж идэвхижүүлэхэд хяналт тавьж ажиллах



4.3 Сумын хэмжээнд ажлын байр шинээр бий болгох, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, залуучуудыг мэргэжлийн сургалтанд хамруулах, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх замаар ядуурал, ажилгүйдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх

4.4 Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын талаархи бодлогыг хэрэгжүүлэх, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүх талаар дэмжиж ажиллах

4.5 Соёл урлаг, зайны сургалтын үйл ажиллагааг тогтмолжуулах, алслагдсан хэсэгт амьдарч байгаа иргэдэд хүргэх явуулын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого боловсруулах

4.6 Нийтийн биеийн тамир, спортод өргөн олныг хамруулан эрчимтэй хөгжүүлэх бодлого явуулж энэ талаархи үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх

4.7 Нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар байгууллага аж ахуйн нэгж, иргэд хамт олныг дэмжлэг туслалцаа авч ажиллах, хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авах архидан согтуурах явдалтай хийх тэмцлийг бүх нийтийнх болгох

#### **Тав. Дэд бүтэц, сумын төвийн тохижилт, байгаль орчны бодлогын талаар**

**Дэд бүтэц, сумын төвийн тохижилт, экологийн бодлогыг зөв тодорхойлж иргэдийн амьдрах ая тухтай орчин бий болгоход шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.**

5.1 Сумын төвийн хөгжлийн хүрээнд сумын төвийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг хийлгэж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хяналт тавьж ажиллах, дэд бүтцийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах

5.2 Иргэдийг орон сууцаар хангах боломж бололцоог бий болгох, төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны системд холбох

5.3 Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүний биелэлтэнд хяналт тавьж жил бүр ИТХ-аар хэлэлцүүлж байх

5.4 Гэр хорооллыг амины орон сууцны тохилог хороолол болгон хөгжүүлэх үндэс суурийг тавьж усан хангамж, эрчим хүчний дэд бүтцийг бий болгох найдвартай ажиллагааг хангах гудамж, хашааны тохижилт гэрэлтүүлгийг сайжруулах талаар бодлого боловсруулж хэрэгжилтийг хангах

5.5 Орон нутгийг биеэ даасан байдлаар хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татан оруулах, иргэд хөдөлмөрчдийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх талаар анхаарал тавьж ажиллах.

5.6 Сумын хэмжээнд байгалийн гамшиг, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд энэ талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд хөдөлмөрчидтэй хамтран ажиллах